



ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот

Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шинээр олгох, сунгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 11.6, Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэх талаар санал, дүгнэлт боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн 2026 оны 04 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн дүүргийн нутаг дэвсгэрт тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгах 3 хуулийн этгээдийн нэрсийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон аж ахуйн нэгж байгууллагын тамхи худалдах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Номин)-т, Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Т.Баатар), хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.МАНДУУЛ